



## ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/03

Бэрх хот

### Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Хэнтий Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1.1, 2.1.2, 2.1.3 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Нийгмийн бодлогын асуудал  
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Нягтлан бодогч

Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан

Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал

хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд нь Хэнтий Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон өмчийн бүртгэл, хамгаалалт, бүрэн бүтэн байдал, хэрэглээ, байнгын ашиглалтад хяналт тавьж ажилласугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Захирагчийн ажлын албаны даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/03 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА  Э.МЯГМАРСҮРЭН

•232 603 002